



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 5/1034

Улаанбаатар хот

Б.Баярнямыг ажлаас чөлөөлж, нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэг, 82 дугаар зүйлийн 82.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.7, 271¹.1.10 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан “Чингис хаан” олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын ариутгагч Бэх-Очирын Баярнямыг 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Б.Баярнямд төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж болох 10.231.650 (арван сая хоёр зуун гучин нэгэн мянга зургаан зуун тавин) төгрөгийг холбогдох журмын дагуу олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Долгорсүрэн)-т зөвшөөрсүгэй.

3. Ажлаас чөлөөлөгдөж байгаа Б.Баярнямтай холбогдох тооцоог зохих журмын дагуу хийж, ажил хүлээлцэхийг “Чингис хаан” олон улсын нисэх буудал дахь гаалийн газар (Г.Баасандорж)-т даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Д.Бат-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА



Р.ОТГОНЖАРГАЛ

1439501 3549